



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Өгийнуур сумын хүүхдийн цэцэрлэг 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2026/78/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.open.audit.mn Архангай аймаг 2026 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn Аудитыг гүйцэтгэсэн: Гроут финанс Аудит ХХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Бямбадорж Утас: 77721628 Цахим хаяг: Byambadorj@growthfinance.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2026.02.24 № 61
танай _____-ны № _____-т

АРХАНГАЙ АЙМГИЙН ӨГИЙНУУР
СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Ж.БАДАМ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Өгийнуур сумын хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудал

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх “сургуулийн өмнөх боловсрол” хөтөлбөрийн хүрээнд 11 арга хэмжээг санхүүжүүлэхээр нийт 899,506.6 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрдүүлж, гүйцэтгэлээр 846,177.2 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 8 үндсэн зорилтын хүрээнд 37 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг аймгийн Боловсролын газраас 90.8 хувьтай үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөгөөр)

Дансны код	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	206,382,544.76	127,202,466.23
31	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	151,974,476.76	66,235,509.23
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	151,974,476.76	66,235,509.23
3121	Төгрөг	151,974,476.76	66,235,509.23
31211	Төрийн сангийн харилцах	151,974,476.76	66,235,509.23
33	АВЛАГА	0.00	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	54,408,068.00	60,966,957.00
354	Хангамжийн материал	54,408,068.00	60,966,957.00
35410	Бичиг хэргийн материал	344,000.00	3,334,200.00
35420	Аж ахуйн материал	54,064,068.00	57,632,757.00
346	Урьдчилж төлсөн зардал, тооцоо	0.00	0.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	199,716,396.44	191,493,799.26
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	199,716,396.44	191,493,799.26
392	Биет хөрөнгө	194,124,396.44	185,901,799.26
39201	Барилга, байгууламж, орон сууц	276,800,400.00	276,800,400.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(120,045,480.94)	(139,865,524.18)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	30,807,960.00	32,294,115.20
39206	Хуримтлагдсан элэгдэл	(13,321,913.43)	(9,294,356.47)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	26,472,328.13	23,689,508.13
39208	Хуримтлагдсан элэгдэл	(19,636,006.45)	(9,778,572.55)
39214	Бусад үндсэн хөрөнгө	21,323,200.00	20,943,200.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(10,470,400.00)	(11,081,280.00)
39217	Ном	2,194,309.13	2,194,309.13
393	Биет бус хөрөнгө	5,592,000.00	5,592,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	5,592,000.00	5,592,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	406,098,941.20	318,696,265.49
4	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	0.00	0.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	0.00
413	Өглөг	0.00	0.00
4136	Бусад өглөг	0.00	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	406,098,941.20	318,696,265.49
51	Засгийн газрын хувь оролцоо	406,098,941.20	318,696,265.49
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	205,208,529.48	205,208,529.48
51101	Өмч: - төрийн	205,208,529.48	205,208,529.48
512	Хуримтлагдсан үр дүн	179,142,920.33	92,036,844.62
51210	Өмнөх үеийн үр дүн	179,142,920.33	179,439,520.33
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	(87,402,675.71)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	21,747,491.39	21,450,891.39
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	406,098,941.20	318,696,265.49

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөгөөр)

Дансны код	Балансын зүйл	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	749,742,020.00	788,471,435.20
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	10,518,620.00	26,159,635.20
120	Нийтлэг татварын бус орлого	10,518,620.00	26,159,635.20
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	70,000.00	8,895,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	70,000.00	105,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	8,790,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- үндсэн хөрөнгө	9,368,620.00	2,306,835.20
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого – Бараа материал	1,080,000.00	14,957,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	739,223,400.00	762,311,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	685,650,800.00	703,839,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	685,650,800.00	703,839,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	53,572,600.00	58,472,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	53,572,600.00	58,472,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	723,894,521.44	875,874,110.91
21	УРСГАЛ ЗАРДАЛ	723,894,521.44	875,874,110.91
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	709,169,823.24	864,883,458.44
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	489,913,133.00	602,857,138.00
210101	Цалин	330,528,464.00	371,883,087.00
210102	Нэмэгдэл цалин	141,455,969.00	179,653,084.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	8,320,000.00
210104	Урамшуулал	17,928,700.00	43,000,967.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	59,830,383.16	73,646,229.53
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	40,760,732.87	50,539,224.30
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	4,855,682.52	5,616,758.19
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	2,414,641.68	2,956,541.23
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	2,322,223.48	2,956,541.63
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	9,477,102.61	11,577,164.18
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	45,817,501.80	51,238,347.53
210301	Гэрэл цахилгааны зардал	2,320,802.60	3,688,853.29
210302	Түлш, халаалтын зардал	43,266,699.20	46,794,494.24
210303	Цэвэр, бохир усны зардал	230,000.00	755,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	10,239,711.00
210408	Бараа материал актальсны зардал	-	10,239,711.00
2105	Нормативт зардал	57,409,200.00	66,686,050.00
210502	Хоол, хүнс	57,409,200.00	66,686,050.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,000,000.00	5,255,100.00
210604	Урсгал засвар	5,000,000.00	5,255,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	1,151,800.00	2,216,000.00
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	1,151,800.00	2,216,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	50,047,805.28	52,744,882.38
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,187,901.83	20,315,036.66
210902	Хичээл үйлвэрлэлийн дадлага хийх	4,047,550.00	4,480,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	26,812,353.45	27,948,945.72
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,724,698.20	10,990,652.47
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,969,600.00	9,012,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,969,600.00	9,012,100.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,755,098.20	1,978,552.47
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,755,098.20	1,978,552.47
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	25,847,498.56	(87,402,675.71)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	25,847,498.56	(87,402,675.71)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөгөөр)

Архангай аймгийн Өгийнуур сумын хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	739,293,400.00	762,416,800.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	70,000.00	105,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	70,000.00	105,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	70,000.00	105,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	70,000.00	105,000.00
120009	Бусад орлого	-	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	739,223,400.00	762,311,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	685,650,800.00	703,839,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	685,650,800.00	703,839,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	53,572,600.00	58,472,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	53,572,600.00	58,472,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	704,446,167.99	839,508,587.53
21	УРСГАЛ ЗАРДАЛ	704,446,167.99	839,508,587.53
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	689,721,469.79	828,517,935.06
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	489,913,133.00	602,857,138.00
210101	Үндсэн цалин	330,528,464.00	371,883,087.00
210102	Нэмэгдэл	141,455,969.00	179,653,084.00
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	-	8,320,000.00
210104	Урамшуулал	17,928,700.00	43,000,967.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	59,830,383.16	73,646,229.53
210201	Тэтгэврийн даатгал	40,760,732.87	50,244,600.05
210202	Тэтгэмжийн даатгал	4,855,682.52	5,911,382.44
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,414,641.68	2,956,541.23
210204	Ажилгүйдлийн даатгал	2,322,223.48	2,956,541.63
210205	Эрүүл мэндийн даатгал	9,477,102.61	11,577,164.18
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	45,817,501.80	51,238,347.53
210301	Гэрэл, цахилгаан	2,320,802.60	3,688,853.29
210302	Түлш, халаалт	43,266,699.20	46,794,494.24
210303	Цэвэр, бохир ус	230,000.00	755,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	-
2105	Нормативт зардал	57,409,200.00	66,686,050.00
210502	Хоол, хүнс	57,409,200.00	66,686,050.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,000,000.00	5,255,100.00
210604	Урсгал засвар	5,000,000.00	5,255,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,051,800.00	2,216,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,051,800.00	2,216,000.00
210807	Газрын төлбөр	0.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	29,699,451.83	26,619,070.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23,714,651.83	20,949,970.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,984,800.00	5,669,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,724,698.20	10,990,652.47
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,969,600.00	9,012,100.00

Архангай аймгийн Өгийнуур сумын хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,969,600.00	9,012,100.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,755,098.20	1,978,552.47
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг -Орон нутгийн төсөв	2,755,098.20	1,978,552.47
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	34,847,232.01	(77,091,787.53)
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	6,450,000.00	8,647,180.00
	Дотоод эх үүсвэрээр	6,450,000.00	8,647,180.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	6,450,000.00	8,647,180.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(6,450,000.00)	(8,647,180.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	28,397,232.01	(85,738,967.53)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	123,577,244.75	151,974,476.76
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	151,974,476.76	66,235,509.23

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	205,208,529.48	21,747,491.39	153,295,421.77	380,251,442.64
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	205,208,529.48	21,747,491.39	153,295,421.77	380,251,442.64
Тайлант үеийн үр дүн	-	-	25,847,498.56	25,847,498.56
2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	205,208,529.48	21,747,491.39	179,142,920.33	406,098,941.20
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	205,208,529.48	21,747,491.39	179,142,920.33	406,098,941.20
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(296,600.00)	296,600.00	-
Тайлант үеийн үр дүн	-	-	(87,402,675.71)	(87,402,675.71)
2025 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	205,208,529.48	21,450,891.39	92,036,844.62	318,696,265.49

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Бүртгэлийн дансны код	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		899,506,600.00	846,177,215.06	53,329,384.94	94.07
УРСГАЛ ЗАРДАЛ		899,506,600.00	846,177,215.06	53,329,384.94	94.07
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		890,494,500.00	837,165,115.06	53,329,384.94	94.01
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил		642,816,300.00	602,857,138.00	39,959,162.00	93.78
Үндсэн цалин	210101	396,403,700.00	371,883,087.00	24,520,613.00	93.81
Нэмэгдэл	210102	210,058,200.00	179,653,084.00	30,405,116.00	85.53
Унаа хоолны Хөнгөлөлт	210103	-	8,320,000.00	(8,320,000.00)	-
Урамшуулал	210104	36,354,400.00	43,000,967.00	(6,646,567.00)	118.28
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		79,556,800.00	73,646,229.53	5,910,570.47	92.57
Тэтгэврийн даатгал	210201	53,994,200.00	50,244,600.05	3,749,599.95	93.06
Тэтгэмжийн даатгал	210202	6,390,700.00	5,911,382.44	479,317.56	92.50
ҮОМШӨ-ний даатгал	210203	3,195,300.00	2,956,541.23	238,758.77	92.53
Ажилгүйдлийн даатгал	210204	3,195,300.00	2,956,541.63	238,758.37	92.53
Эрүүл мэндийн даатгал	210205	12,781,300.00	11,577,164.18	1,204,135.82	90.58
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		53,216,900.00	51,238,347.53	1,978,552.47	96.28
Гэрэл, цахилгаан	210301	5,075,900.00	3,688,853.29	1,387,046.71	72.67
Түлш, халаалт	210302	47,021,000.00	46,794,494.24	226,505.76	99.52
Цэвэр, бохир ус	210303	1,120,000.00	755,000.00	365,000.00	67.41
Хангамж, бараа материалын зардал		-	-	-	-
Нормативт зардал		71,682,400.00	66,686,050.00	4,996,350.00	93.03
Хоол, хүнс	210502	71,682,400.00	66,686,050.00	4,996,350.00	93.03
Эд хогшил, урсгал засварын зардал		5,255,100.00	5,255,100.00	-	100.00
Урсгал засвар	210604	5,255,100.00	5,255,100.00	-	100.00
Томилолт, зочны зардал		-	-	-	-
Дотоод албан томилолт	210702	-	-	-	-
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		2,695,700.00	2,216,000.00	479,700.00	82.20
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	210806	2,695,700.00	2,216,000.00	479,700.00	82.20
Газрын төлбөр	210807	-	-	-	-
Бараа үйлчилгээний бусад зардал		35,271,300.00	35,266,250.00	5,050.00	99.99
Бараа үйлчилгээний бусад зардал	210901	29,602,200.00	29,597,150.00	5,050.00	99.98
Хичээл үйлдвэрлэлийн дадлага	210902	5,669,100.00	5,669,100.00	-	100.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		9,012,100.00	9,012,100.00	-	100.00
Засгийн газрын урсгал шилжүүлэг		-	-	-	-
Засгийн газрын дотоод шилжүүлэг	261090	-	-	-	-
Бусад урсгал шилжүүлэг		9,012,100.00	9,012,100.00	-	100.00
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	213208	-	-	-	-
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	213209	9,012,100.00	9,012,100.00	-	100.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		899,506,600.00	760,438,247.53	139,068,352.47	84.54
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ		840,929,600.00	703,839,800.00	137,089,800.00	83.70
Улсын төсвөөс санхүүжих	131001	707,078,400.00	703,839,800.00	3,238,600.00	99.54
Оны эхний үлдэгдлээс санхүүжих	131009	133,851,200.00	-	133,851,200.00	-
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ		58,472,000.00	56,493,447.53	1,978,552.47	96.62
Орон нутгийн төсвөөс	132001	58,472,000.00	56,493,447.53	1,978,552.47	96.62

Архангай аймгийн Өгийнуур сумын хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС		105,000.00	105,000.00	-	100.00
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1200042	105,000.00	105,000.00	-	100.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		151,974,476.76	151,974,476.76	-	100.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		151,974,476.76	66,235,509.23	85,738,967.53	43.58
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ					
БАЙГУУЛЛАГЫН ТОО					
АЖИЛЛАГСАДЫН ТОО		22	22.00	-	100.00
Удирдах ажилтан		1	1	-	100.00
Гүйцэтгэх ажилтан		10	10	-	100.00
Үйлчлэх ажилтан		11	11	-	100.00
СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)		260	260	-	100.00
Төрийн өмчит СӨБ байгууллага		1	1	-	100.00
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ		22.5	22.5	-	100.00
СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)		10	10	-	100.00
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)		12.5	12.5	-	100.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа¹ илрээгүй тул залруулга хийгээгүй.

Аудитаар залруулаагүй 4,826.2 мянган төгрөгийн зөрчил² илэрч 889.9 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 3,936.3 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүллээ.

Аудитаар залруулагдаагүй 4 зөрчилтэй асуудлын материаллаг алдаа зөрчил нь 4,826.2 мянган төгрөг бөгөөд гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 10,135.1 мянган төгрөгөөс бага байх тул **Өөрчлөлтгүй дүгнэлт** өглөө.

3.1 Төлбөрийн акт

3.1.1. 2025 оны 4-р сард 2-оос 4 сарын хоолны хөнгөлөлтийг нөхөн олгохдоо ажилласан болон хоолны хөнгөлөлт олговол зохих хоногоор, нотлох анхан шатны баримтыг үндэслэн тооцоогүйгээс 18 ажилтанд 495.0 мянган төгрөг илүү олгосон байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.3 "гүйцэтгэсэн ажил үүрэгтээ тохирсон цалин хөлс авах" мөн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт буцаан төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

3.1.2. Цалин, нэмэгдэл урамшууллын зардлыг хянаж үзэхэд нэр бүхий 3 ажилтанд 394.9 мянган төгрөгийн цалин илүү тооцон олгожээ. Үүний 266.6 мянган төгрөгийн дүн нь цагийн бүртгэлээс зөрүүтэйгээр 1 ажилтны цалин бодсонтой, 128.3 мянган төгрөгийн дүн нь улирлын урамшууллын дүгнэсэн хувийг 2 ажилтны тухайд зөрүүтэй оруулснаас болжээ.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.3 "гүйцэтгэсэн ажил үүрэгтээ тохирсон цалин хөлс авах" мөн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "Үнэн зөв байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэсэн заалтыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт буцаан төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

3.2 Албан шаардлага

3.2.1. "Балансын урамшуулал олгох тухай" Архангай аймгийн Боловсролын газрын даргын 2025.09.03-ны өдрийн А/38 дугаар тушаал, тус цэцэрлэгийн эрхлэгчийн 2025.09.03-ны өдрийн Б/28 дугаар тушаалуудыг үндэслэн "2024 санхүүгийн тайланд өөрчлөлтгүй дүгнэлт авсан гэсэн үндэслэлээр нягтлан бодогчид 792.0 мянган төгрөгийн, няравт 1,105.0 мянган төгрөг нийт "балансын урамшуулал" 1,897.0 мянган төгрөгийг "улирлын үр дүнгийн урамшуулал"-тай давхардуулан олгосон нь хууль, журамд нийцэхгүй байна.

Энэ нь "Төрийн хэмнэлтийн тухай" хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно": 15.1.3 "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", "Төрийн албаны тухай" хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.Онцгой чухал буюу онц түвэгтэй албан даалгавар биелүүлсэн, байгууллагын үйл ажиллагаа, зохион байгуулалт, үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр шинэ санал, санаачилга гаргаж хэрэглээнд нэвтрүүлсэн болон бусад нөхцөл, шаардлагыг хангасан

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

төрийн албан хаагчийг дараахь хэлбэрээр шагнаж, урамшуулна: 51.1.4 "улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх.

3.2.2. Багш ажилтнуудын гүйцэтгэлийн үнэлгээний урамшуулалд 8,110.9 мянган төгрөгийг 18 ажилтанд олгохдоо зөвхөн "Хувь хүний орлогын албан татвар" 10 хувь болох 901.2 мянган төгрөгийг суутгасан байх бөгөөд 2,039.3 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг суутган авч, төсөвт төлөөгүй байна.

Энэ нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 19 дугаар зүйлийн 19.1 "Даатгуулагч, ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл ногдох орлогын бүрэлдэхүүнд дараах цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг хамааруулна": 19.1.1 "Хөдөлмөрийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.5 дахь хэсэг, 101 дүгээр зүйлийн 101.1 дэх хэсэг, 111, 112, 113, 114, 115, 116, 117 дугаар зүйлд тус тус заасан цалин хөлс, олговор" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс		Албан шаардлага		Зөвлөмж	
			Төлбөрийн акт					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Цалин илүү тооцож олгосон	1	394.9	1	394.9				
Хоолны хөнгөлөлт илүү тооцож олгосон	1	495.0	1	495.0				
Балансын урамшуулал олгосон	1	1,897.0			1	1,897.0		
НДШ суутган буюу ногдуулаагүй.	1	2,039.3			1	2,039.3		
Дүн	4	4,826.2	2	889.9	2	3,936.3	-	-